



## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халиун сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2025/013/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Алтай хот

2026 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: [erdenechimegd@audit.gov.mn](mailto:erdenechimegd@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: [Tserenkhandd@audit.gov.mn](mailto:Tserenkhandd@audit.gov.mn)

Аудитор: Э.Сүнжидмаа

Утас: 80048599 Цахим хаяг: [Sunjidmaae@audit.gov.mn](mailto:Sunjidmaae@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есенбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 03. 24 № 142

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Халиун сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Халиун сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доор зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

Засаг даргын нөөц хөрөнгө арга хэмжээний зардлаас ой тэмдэглэх, туршлага судлах, ажилчдад дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийн үзлэг оношилгоо хийлгэх, айл өрхөд дэмжлэг үзүүлэх, уулзалт тэмцээн зохион байгуулах зэрэгт 24.3 сая төгрөг зарцуулсан,

Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 110.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-д, 16 дугаар

822511000425

зүйлийн 16.5.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-д заасан заалтуудыг зөрчсөн нь санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Ёлтонгийн услалтын систем ашиглалтад орж, бүрэн хүчин чадлаар ажиллаж эхэлсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Тайлант онд сумын нийт төсвийг 2,380.1 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 1,966.5 сая төгрөгийг зарцуулж, 82.6 хувийн биелэлттэй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 8 хөтөлбөр 81 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 90.6 хувиар дүгнэсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	860,667.7	1,066,264.7
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	222,075.6	426,149.9
3	АВЛАГА	195,879.1	190,497.8
4	БАРАА МАТЕРИАЛ	238,852.6	246,471.6
5	НӨӨЦИЙН БАРАА	111,310.4	136,310.4
6	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	92,550.0	66,835.0
7	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,383,328.3	11,667,193.0
8	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,383,328.3	11,667,193.0
9	2.2.02	2,257,834.5	7,541,699.2
10	2.2.03	4,125,493.8	4,125,493.8
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	7,243,996.0	12,733,457.7
12	НИЙТ ӨР ТӨЛБӨР	111,220.7	98,898.5
13	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	111,220.7	98,898.5
14	1.1.03	111,220.7	98,898.5
15	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,132,775.3	12,634,559.2
16	Засгийн газрын хувь оролцоо	7,132,775.3	12,634,559.2
17	Засгийн газрын оруулсан капитал	428,609.0	428,609.0
18	дүн	6,499,956.8	12,001,740.6
19	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	204,209.6	204,209.6
20	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	7,243,996.0	12,733,457.7

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,939,117.9	8,178,582.7
2	ТАТВАРЫН ОРЛОГО	437,987.1	448,683.0
3	Орлогын албан татвар	367,359.4	343,990.2
4	Хувь хүний орлогын албан татвар	383,226.4	371,707.0
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(15,867.1)	(27,716.8)
6	Хөрөнгийн албан татвар	55,253.9	81,978.1
7	Бусад татвар, төлбөр, хураамж	15,373.9	22,714.7
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	129,412.9	7,729,899.7
9	Тусламжийн орлого	-	1,483,693.9

10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,371,717.9	-
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,873,710.7	2,668,478.8
12	УРСГАЛ ЗАРДАЛ	1,873,710.7	2,668,478.8
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,833,991.2	2,664,583.8
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	738,721.4	775,940.8
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,943.1	137,003.6
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	413,236.8	528,933.8
17	Хангамж, бараа материалын зардал	125,399.0	157,768.2
18	Эд хогшил, урсгал засварын зардал	47,964.7	50,210.3
19	Томилолт, зочны зардал	11,226.8	5,636.0
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,826.5	202,448.7
21	Бараа үйлчилгээний бусад зардал	312,672.9	806,642.4
22	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,719.5	3,895.0
23	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	65,407.2	5,510,103.8
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	42,276.6	-
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(42,276.6)	-
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	23,130.6	5,510,103.8

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	7,109,571.5	7,109,571.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	73.2	73.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,109,644.8	7,109,644.8
4	Тайлант үеийн үр дүн	23,130.6	23,130.6
5	2024 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	7,132,775.3	7,132,775.3
6	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,132,775.3	7,132,775.3
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(8,320.0)	(8,320.0)
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,124,455.3	7,124,455.3
9	Тайлант үеийн үр дүн	5,510,103.8	5,510,103.8
10	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	12,634,559.2	12,634,559.2

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,897,977.3	2,181,833.2
2	ТАТВАРЫН ОРЛОГО	437,987.1	448,683.0
3	Орлогын албан татвар	367,359.4	343,990.2
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(15,867.1)	(27,716.8)
5	Хөрөнгийн албан татвар	55,253.9	81,978.1
6	Бусад татвар, төлбөр, хураамж	15,373.9	22,714.7
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,206.8	5,393.6
8	Газрын төлбөр	8,659.7	7,589.3
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,507.4	9,731.9
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	88,272.3	1,733,150.2
11	Нийтлэг татварын бус орлого	88,272.3	46,228.0
12	Тусламжийн орлого	-	1,483,693.9
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	203,228.3
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,371,717.9	-
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,508,367.8	1,739,114.7
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,508,367.8	1,739,114.7
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,468,648.3	1,735,219.7
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	738,478.0	775,940.8
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,096.6	187,435.2
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	355,244.6	570,951.8
21	Хангамж, бараа материалын зардал	75,934.4	50,928.4
22	Эд хогшил, урсгал засварын зардал	47,796.3	52,369.8
23	Томилолт, зочны зардал	11,226.8	5,636.0
24	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,537.3	11,736.0
25	Бараа үйлчилгээний бусад зардал	151,334.4	80,221.7
26	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,719.5	3,895.0
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	389,609.5	442,718.5
28	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	424,619.0	208,355.4
29	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	424,619.0	208,355.4
30	Дотоод эх үүсвэрээр	424,619.0	208,355.4

31	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(424,619.0)	(208,355.4)
32	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	973.7	30,288.8
33	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(973.7)	(30,288.8)
34	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(35,983.2)	204,074.3
35	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	258,058.8	222,075.6
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	222,075.6	426,149.9

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Зардлын үзүүлэлт	төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,380,173.1	2,155,307.7	224,865.4	90.6
11	Татварын орлого	426,839.9	448,683.0	(21,843.1)	105.1
110	Орлогын албан татвар	298,228.6	343,990.2	(45,761.6)	115.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	325,945.4	371,707.0	(45,761.6)	114.0
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	265,921.1	322,469.9	(56,548.8)	121.3
110002	Үйл ажиллагааны орлого	5,930.0	8,146.2	(2,216.2)	137.4
110003	Хөрөнгийн орлого	15,600.0	17,614.3	(2,014.3)	112.9
110004	Шууд бус орлого	38,494.3	23,476.5	15,017.8	61.0
110008	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(27,716.8)	(27,716.8)	(0.0)	100.0
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(27,716.8)	(27,716.8)	(0.0)	100.0
110101	Хөрөнгийн албан татвар	107,350.0	81,978.1	25,371.9	76.4
113	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	3,200.0	3,612.1	(412.1)	112.9
113001	Бууны албан татвар	2,150.0	2,250.0	(100.0)	104.7
113002	Малд ногдуулах албан татвар	102,000.0	76,116.0	25,884.1	74.6
113004	Бусад татвар, төлбөр, хураамж	5,361.3	5,393.6	(32.3)	100.6
118	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,361.3	5,393.6	(32.3)	100.6
1180	Улсын тэмдэгтийн хураамж	1,861.3	1,868.4	(7.1)	100.4

118001	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	500.0	500.0	-	100.0
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3,000.0	3,025.2	(25.2)	100.8
1181	Газрын төлбөр	6,500.0	7,589.3	(1,089.3)	116.8
118101	Газрын төлбөр	6,500.0	7,589.3	(1,089.3)	116.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	9,400.0	9,731.9	(331.9)	103.5
118202	Ойн нөөц ашигласны төлбөр	1,300.0	1,307.4	(7.4)	100.6
118203	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	7,600.0	7,904.5	(304.5)	104.0
12	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	500.0	520.0	(20.0)	104.0
120	Татварын бус орлого	3,164.5	43,345.5	(40,181.0)	1,369.7
120003	Нийтлэг татварын бус орлого	3,164.5	43,345.5	(40,181.0)	1,369.7
120004	Торгуулийн орлого	1,964.5	2,762.9	(798.4)	140.6
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	-	32,715.0	(32,715.0)	
120009	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	-	4,867.6	(4,867.6)	
122	Түрээсийн орлого	1,200.0	3,000.0	(1,800.0)	250.0
122003	Тусламжийн орлого	1,950,168.7	1,663,279.2	286,889.5	85.3
122005	Аймаг нийслэлээс авсан татаас	1,460,050.9	1,460,050.9	-	100.0
123002	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	205,281.1	203,228.3	2,052.8	99.0
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	205,281.1	203,228.3	2,052.8	99.0
	Өмнөх оны эхний үлдэгдлээс	284,836.7		284,836.7	-
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,380,173.1	1,966,482.7	(413,690.4)	82.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,830,055.9	1,732,953.5	(97,102.4)	94.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,824,155.9	1,729,058.5	(95,097.4)	94.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	799,549.7	775,940.8	(23,608.9)	97.0
210101	Үндсэн цалин	501,157.3	467,429.2	(33,728.1)	93.3
210102	Нэмэгдэл	196,286.1	273,714.0	77,427.9	139.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	4,984.0	4,984.0	
210104	Урамшуулал	39,302.7	18,543.6	(20,759.1)	47.2

210105	Гэрээт ажлын хөлс	62,803.6	11,270.0	(51,533.6)	17.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	195,452.4	187,435.2	(8,017.2)	95.9
210201	Тэтгэврийн даатгал	120,289.3	116,554.5	(3,734.8)	96.9
210202	Тэтгэмжийн даатгал	45,040.7	39,789.0	(5,251.7)	88.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,020.4	5,534.3	513.9	110.2
210204	Ажилгүйдлийн даатгал	5,020.4	5,500.0	479.6	109.6
210205	Эрүүл мэндийн даатгал	20,081.6	20,057.4	(24.2)	99.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	614,822.4	570,951.8	(43,870.6)	92.9
210301	Гэрэл, цахилгаан	29,255.5	19,649.7	(9,605.8)	67.2
210302	Түлш, халаалт	582,247.0	549,992.1	(32,254.9)	94.5
210303	Цэвэр, бохир ус	3,319.9	1,310.0	(2,009.9)	39.5
2104	Хангамж, бараа материалын зардал	60,424.8	50,928.4	(9,496.5)	84.3
210401	Бичиг хэрэг	8,600.0	5,629.1	(2,970.9)	65.5
210402	Тээвэр, шатахуун	43,600.0	39,513.3	(4,086.7)	90.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,924.8	3,425.3	(499.6)	87.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000.0	607.0	(393.0)	60.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,300.0	1,753.7	(1,546.3)	53.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,800.0	57,319.8	14,519.8	133.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,800.0	4,950.0	(850.0)	85.3
210604	Урсгал засвар	37,000.0	52,369.8	15,369.8	141.5
2107	Томилолт, зочны зардал	11,800.0	5,636.0	(6,164.0)	47.8
210702	Дотоод албан томилолт	11,800.0	5,636.0	(6,164.0)	47.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,364.0	7,731.0	(9,633.0)	44.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,734.0	6,600.0	(5,134.0)	56.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	710.0	403.2	(306.8)	56.8
210803	Даатгалын үйлчилгээ	200.0	115.8	(84.2)	57.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	840.0	-	(840.0)	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	420.0	22.0	(398.0)	5.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,330.0	590.0	(740.0)	44.4

210807	Газрын төлбөр	2,130.0	-	(2,130.0)	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,942.6	73,115.5	(8,827.1)	89.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,000.0	68,929.5	(3,070.5)	95.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,942.6	4,186.0	(5,756.6)	42.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,900.0	3,895.0	(2,005.0)	66.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,900.0	3,895.0	(2,005.0)	66.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	451,225.7	203,240.4	(247,985.3)	45.0
223001	Бусад хөрөнгө	451,225.7	203,240.4	(247,985.3)	45.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	98,891.5	30,288.8	(68,602.7)	30.6
230001	Эргэж төлөгдөх зээл	98,891.5	30,288.8	(68,602.7)	30.6
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	222,075.6	222,075.6	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	426,149.8	426,149.8	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	23,643.0
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,643.0
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,349.4
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,293.5
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,276.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,276.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,276.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,005.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,005.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,271.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,271.2
4	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,366.7

## 3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### Харьяа байгууллагууд

Халиун сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 5 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, бага сургууль) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан, Орон нутгийн хөгжлийн сан, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, бага сургууль, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

### **3.1 Аудитаар Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил**

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 2,061.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 2 алдааг залруулж, 93.9 сая төгрөгийн зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 60.8 сая төгрөгийн 3 зөвлөмж, 1 албан тушаалтанд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

### **3.2 Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил**

Аудитаар санхүүгийн тайлангийн бүртгэл, тайлагналыг 297.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 9 алдааг залруулж, 73.5 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 58.2 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

### **3.3 Төсвийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:**

- ✓ Аудитаар 6.5 сая төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулсан байна.

**Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой** Санхүүгийн байдлын тайланд бараа материалын зардлыг 4.5 сая төгрөгөөр бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 2.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулав.

Залруулагдаагүй нийт 65.2 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын төвшнөөс бага бөгөөд харьяа байгууллагуудын материаллаг зөрчил 286.5 сая төгрөг байгаа тул шинж чанарыг харгалзан үзэж “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар 65.2 сая төгрөгийн 2 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлсэн.

### **3.4 Албан шаардлага**

Төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 286.5 сая төгрөгийн төгрөгийн 11 зөрчил илэрч 167.6 сая төгрөгийн 2 зөрчил арилгах албан шаардлага, 118.9 сая төгрөгийн 8 зөвлөмж, сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлага хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа  
байгууллагуудын үйл ажиллагаанд тавих

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

хяналтыг сайжруулж, санхүүгийн дотоод хяналт хийх

### **3.5 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **Нэг. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой**

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгө арга хэмжээний зардлаас Засагт хааны хот айл гэр зусланд 4.0 сая төгрөгийг, газар тариалан эрхэлж байгаа айлуудад тор худалдан авахад 1.1 сая төгрөгийг, үе үеийн нөхөрсөг уулзалтад 3.0 сая төгрөгийг, Монгол Улсын баатрын 90 жилийн ойг тэмдэглэхэд 5.0 сая төгрөгийг, эрүүл мэндийн үзлэг оношилгооны зардалд 8.2 сая төгрөгийг, туршлага судлахад 2.0 сая төгрөгийн ажилчдад дэмжлэг 1.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1-т "Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна", 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжид нийцүүлэн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг зориулалтын дагуу зарцуулах

Илрүүлэлт: Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үзэхэд шууд бус орлого 15,017.2 мянган төгрөгөөр, малд ногдуулах албан татвар 25,884.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", халиун сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дугаар сарын 15-ны өдрийн 11 дүгээр тогтоолд заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогыг бодит тооцоололд үндэслэн оновчтой төлөвлөж, биелэлтийг хангуулан ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Халиун сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	1	6,528.00			1	6,528.00	1	6,528.00	-	-		-
Халиун сумын ЗДТГ	3	2,061,407.00	1	2,035,158.90	2	26,248.10	3	2,061,407.00	-	-		-
Халиун сумын ИТХ	2	5,301.10			2	5,301.10	2	5,301.10	-	-		-
Халиун сумын ОНХС	4	254,049.10			4	254,049.10	4	254,049.10	-	-		-
Халиун сумын ХХС	3	37,726.50	1	36,260.00	2	1,466.50	3	37,726.50				
<b>Дүн</b>	<b>13</b>	<b>2,365,011.70</b>	<b>2</b>	<b>2,071,418.90</b>	<b>11</b>	<b>293,592.80</b>	<b>13</b>	<b>2,358,483.70</b>	-	-	-	-

## 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Бүгд	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс таггалзах түүвэрт	Нийт зөрчил		Үүнээс										
								Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
						Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Халиун сумын Засаг даргын нэгтгэсэн тайлан	1		1	-	-	-	3	65,221.7	-	-	1	-	2	65,221.7	-	-	-	-
Халиун сумын ЗДТГ	1		1	-	-	-	7	154,777.40	-	-	1	93,973.1	5	60,804.3	1	-	-	-
Халиун сумын ИТХ	1	-	-	-	-	1	1	4,984.00	-	-	-	-	1	4,984.0	-	-	-	-
Халиун сумын сумын ОНХС	1	-	-	-	-	1	3	126,760.20	-	-	1	73,588.5	2	53,171.7	-	-	-	-
Халиун сумын сумын БХНСС	1	-	-	-	-	1									-	-	-	-
Халиун сумын сумын ХХС	1	-	-	-	-	1									-	-	-	-
<b>Дүн</b>	<b>6</b>		<b>2</b>	-	-	<b>4</b>	<b>14</b>	<b>351,743.3</b>	-	-	<b>3</b>	<b>167,561.60</b>	<b>10</b>	<b>184,181.7</b>	<b>1</b>	-		-